



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

Г О Баяrbатад хариуцлага тооцох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.2 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2021 оны 05/6969 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Спорт бэлтгэлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Очийн Баяrbат нь 2020 оны хөрөнгө орлогын мэдүүлэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн арилжааны банкнууд дахь дансны үлдэгдлийг мэдүүлээгүй бөгөөд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг зөрчсөн нь тогтоогдсон тул түүнд 1 сарын цалин хөлсийг 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл ноогдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг баримталж үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг “Спорт бэлтгэлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал О.Баяrbатад үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ